

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН
20... ОНЫ МЭДЭЭ**

А. ХАЯГИЙН ХЭСЭГ

1. Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл

Байгууллагын нэр							
Регистрийн дугаар							
Аймаг, нийслэл							
Сум, дүүрэг							
Дарга / эзний нэр							
Утасны дугаар							
Үйлчилгээний газрын нэр							
Аймаг, нийслэл							
Сум, дүүрэг							
Утасны дугаар							

1. Аж ахуйн нэгж, байгууллагууд дараа оны 2-р сарын 18-ны дотор сумын Засаг даргын тамгын газар, дүүргийн статистикийн хэлтэст маягтаар ирүүлнэ.
2. Сумдын тамгын газар, дүүргийн статистикийн хэлтсээс 2-р сарын 25-нд аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газарт маягтаар ирүүлнэ.
3. Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар 3-р сарын 4-нд цахим шуудангаар ҮСГ-т дамжуулна.

2. Аж ахуйн нэгж, байгууллагын төрөл /кодыг дугуйлна уу/

Нэр	код
Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	11
Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	12
Хоршоо	21
Хувьцаат компани	31
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	32
Төрийн өмчит үйлдвэрийн газар	40
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	50
Бусад	80

3. Аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн хэлбэр

/ кодыг дугуйлна уу/

	Нэр	Код
Төрийн	өмчийн	11
	өмчийн оролцоотой	12
	гадаадтай хамтарсан	13
Орон нутгийн	өмчийн	31
	өмчийн оролцоотой	32
	гадаадтай хамтарсан	33
Хувийн	Монгол улсын иргэний	21
	Гадаад улс болон иргэнтэй хамтарсан	22
	Гадаад улсын болон иргэний	23

4. Үйлчилгээний газрын төрөл /кодыг дугуйлна уу/

1- Тур оператор	2- Тур агент	3- Жуулчны бааз	4- Ангийн отог
-----------------	--------------	-----------------	----------------

Б. ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН НИЙТ ЖУУЛЧДЫН ТОО

Үзүүлэлт	МД	Гүйцэтгэл
А	Б	1
1. Үйлчилгээ авсан нийт жуулчдын тоо мөр(1)=мөр(2+3+10)	1	
1.1 Дотоодын жуулчдын тоо	2	
1.2 Гадаадад явуулсан жуулчдын тоо мөр(3)=мөр(4:9)	3	
Үүнээс: - БНХАУ	4	
- Сингапур	5	
- Малайз	6	
- Тайланд	7	
- ОХУ	8	
- Бусад	9	
1.3 Гадаадаас хүлээн авсан жуулчдын тоо мөр(10)=мөр(11:17)	10	
Үүнээс: - БНХАУ	11	
- ОХУ	12	
- БНСУ	13	
- Япон	14	
- АНУ	15	
- ХБНГУ	16	
- Бусад	17	
2. Зохион байгуулсан нийт аяллын тоо мөр(18)=мөр(19:21)	18	
2.1 Дотоодын жуулчдад зориулсан	19	
2.2 Гадаадад явсан жуулчдад зориулсан	20	
2.3 Гадаадаас ирсэн жуулчдад зориулсан	21	

В. ОРЛОГО, ЗАРДАЛ

(мян.төг)

Үзүүлэлт		МД	Гүйцэтгэл
А		Б	1
1. Нийт орлого мөр1=мөр(2+7)		1	
Үндсэн үйл ажиллагааны орлого мөр2=мөр(3+4)		2	
Гадаадын жуулчдаас олсон орлого		3	
Дотоодын жуулчдаас олсон орлого мөр4=мөр(5+6)		4	
Монголд аялуулсан аяллаас олсон орлого		5	
Гадаадад аялуулсан аяллаас олсон орлого		6	
Үндсэн бус үйл ажиллагааны орлого		7	
2. Нийт зардал мөр8=мөр(9+17)		8	
Жуулчидтай холбоотой зардал-Бүгд мөр9=мөр(10+11) ба мөр9=мөр(12:16)		9	
Бүгдээс:	Монголд аялуулсан аялалд зарцуулсан нийт зардал	10	
	Гадаадад аялуулсан аялалд зарцуулсан нийт зардал	11	
Бүгдээс:	-Тээврийн зардал	12	
	-Ор, байрны зардал	13	
	-Хоолны зардал	14	
	-Үзвэр, үйлчилгээний зардал	15	
	-Бусад зардал	16	
Үйл ажиллагааны бусад зардал мөр(17)=мөр(18:43)		17	
-Үндсэн ба нэмэгдэл цалин, шагнал, урамшуулал		18	
-нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл		19	
-Түүхий эд, материалын зардал		20	
-Цахилгаан эрчим хүч		21	
-Шатахуун, шатах, тослох материал		22	
-Түлш (нүүрс, мод, бусад)		23	
-Дулааны эрчим хүч (уур, халуун ус)		24	
-Цэвэр, бохир ус		25	
-Барилга, байшин, тоног төхөөрөмжийн түрээсийн зардал		26	
-Тээврийн зардал		27	
-Томилолтын зардал		28	
-Шуудан, холбооны зардал		29	
-Гадны байгууллагаар үйлчлүүлсний төлбөр		30	
-Засвар, үйлчилгээний зардал		31	
-Өөрийн эзэмшлийн авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар		32	
-Зээлийн хүү		33	
-Газар, байгалийн нөөц ашигласны төлбөр		34	
-Даатгалын зардал		35	
-Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал		36	
-Ажиллагчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн тусламж		37	
-Зарлал, сурталчилгааны зардал		38	
-Бичиг хэргийн зардал		39	
-Сэлбэг хэрэгслийн зардал		40	
-Ажиллагчдын сургалт, давтан сургалтын зардал		41	
-Хөдөлмөр хамгааллын зардал		42	
-Бусад зардал		43	
3. Ашиг, алдагдал		44	

Г. БУСАД ҮЗҮҮЛЭЛТ

(тоогоор)

1. Ажиллагчдын тоо - Бүгд		1	
Бүгдээс:	1.1 Байнгын ажиллагчдын тоо	2	
	1.2 Эмэгтэй	3	
2. Нийт ор (тоогоор)		4	
3. Жуулчдад үйлчилгээ үзүүлсэн хоногийн тоо		5	
4. Жуулчдад үйлчилгээ үзүүлсэн ор хоногийн тоо		6	
5. Компьютерийн тоо		7	

Г. НИЙТ ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛ

МЯН.төг

Үзүүлэлт	МД	БҮГД		Тухайн жилд оруулсан нийт хөрөнгө оруулалт	Өөрийн хөрөнгөөр оруулсан хөрөнгө оруулалт
		оны эхэнд	оны эцэст		
А	Б	1	2	3	4
Үндсэн хөрөнгө мөр 1 = мөр (2 +16)	1				
Биет хөрөнгө мөр 2 =мөр (3+4+8+9+12+13)	2				
Орон сууцны барилга	3				
Бусад барилга, байгууламжууд мөр 4 = мөр (5+6)	4				
<i>орон сууцны бус барилга</i>	5				
<i>бусад байгууламжууд</i>	6				
<i>үүнээс: авто зам</i>	7				
Их засвар, өргөтгөл, шинэчлэлт, сэргээн босголтын ажил	8				
Машин, тоног төхөөрөмж мөр 9=мөр (10+11)	9				
<i>тээврийн хэрэгсэл</i>	10				
<i>бусад машин, тоног төхөөрөмж</i>	11				
<i>Тавилга, эд хогшил</i>	12				
Өсөж үрждэг хөрөнгө мөр13=мөр (14+15)	13				
<i>Ажлын болон ашиг шимийн мал, амьтан</i>	14				
<i>Олон наст ургамал</i>	15				
Биет бус хөрөнгө мөр 16 =мөр (17+18+19+20)	16				
Геологи, хайгуул, зураг төслийн ажил	17				
Компьютерийн программ хангамж	18				
Утга зохиол, урлагийн эх бүтээл	19				
Бусад биет бус үндсэн хөрөнгө	20				
Материаллаг эргэлтийн хөрөнгө мөр 21=мөр (22+23+26+27)	21				
Түүхий эд, материал	22				
Дуусаагүй үйлдвэрлэл мөр 23 = мөр (24+25)	23				
<i>өсөж үрждэг бүтээгдэхүүний дуусаагүй үйлдвэрлэл</i>	24				
<i>бусад дуусаагүй үйлдвэрлэл</i>	25				
Бэлэн бүтээгдэхүүн	26				
Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүн	27				
Үнэт зүйлс мөр 28 = мөр (29+30+31)	28				
Үнэт металл, чулуу	29				
Эртний эдлэл, бүтээл	30				
Бусад үнэт зүйлс	31				
НИЙТ ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛ мөр 32 = мөр (1+21+28)	32				

Нийт хөрөнгийн хуримтлал нь гадаад болон дотоод эх үүсвэрээс санхүүжиж, тайлант жилд эдийн засагт шинээр бий болсон хөрөнгийн хэмжээ бөгөөд олон улсын стандарт ангиллаар үндсэн хөрөнгийн хуримтлал, материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлалаас бүрддэг. Нийт хөрөнгийн хуримтлалд бэлэглэсэн, үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг оруулж тооцно.

Тэмдэглэгээний тайлбар: (:) харгалзах үзүүлэлтүүдийн хоорондох тоонуудын нийлбэр
 Жишээ нь: мөр (2 : 5) = мөр (2 + 3 + 4 + 5)
 (>=) харгалзах үзүүлэлтээс их буюу тэнцүү

Тамга тэмдэгийн
дардас

Захирал (Эзэн).....
 Ерөнхий (ахлах)нягтлан бодогч.....
 Эдийн засагч.....
 200 ... оны ... сарын ... өдөр

**Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын
жилийн мэдээний маягт нөхөх заавар АЖ-1**

Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага графикт хугацаанд үнэн зөв гаргаж мэдээлнэ. **Мэдээлэгч аж ахуйн нэгж байгууллага нь бие даан санхүүгийн тайлан гаргадаг эсэхээс үл хамааран анхан шатны мэдээллийг үндэслэн уг мэдээг гаргана.**

Хувь хүн өөрийн байнга оршин суудаг газар нутгаасаа нэгээс 183 хоногос хэтрэхгүй хугацаагаар амралт, сувилал, танин мэдэхийн зорилгоор болон шашин шүтлэг, ажил мэргэжлийн шугамаар өөр газар нутагт аялан явах хүнийг "жуулчин" гэж үздэг.

Тур оператор гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөх, бүрдүүлэх, сурталчлах, бөөнөөр болон жижиглэнгээр худалдах, аялал зохион байгуулах, виз авахтай холбогдсон болон аяллын бусад бичиг баримтын бүрдүүлэлт хийх, онгоц, төмөр зам болон тээврийн хэрэгслээр зорчих билетийн захиалга хийх, билет худалдах, худалдан авах, зочид буудал, жуулчны бааз, байр, үзвэрийн захиалга хийх, жуулчныг угтан авах, үйлчлэх, үдэн гаргах үйл ажиллагааг зохион байгуулдаг ашгийн төлөө хуулийн этгээдийг; **Тур агент** гэж аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөх, бүрдүүлэх, сурталчлах, бөөнөөр болон жижиглэнгээр худалдах, аялал зохион байгуулахаас бусад тур операторын эрхлэх үйл ажиллагааг бүхэлд нь эсвэл түүний тодорхой хэсгийг, түүнчлэн тур операторын бүтээгдэхүүнийг зуучлан худалдах, худалдан авах үйл ажиллагааг эрхэлдэг ашгийн төлөө хуулийн этгээдийг; **Жуулчны бааз** гэж орон нутагт байрласан, жуулчдын аялах тав тухтай нөхцлийг хангасан байр, хоолны болон бусад төлбөрт үйлчилгээ үзүүлдэг үйлчилгээний цогцолборыг; **Ангийн отог** гэж агнуурын нөөц нутагт байрласан, анчид, жуулчдыг хүлээн авч байр, хоолны болон бусад шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг үйлчилгээний цогцолборыг хэлнэ.

А. Хаягийн хэсэг

Байгууллагын нэр гэдэгт тухайн үйлчилгээний газар (тур оператор, тур агент, жуулчны бааз, ангийн отог)-ийг ажиллуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын нэр, регистрийн дугаар, оршин байгаа аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ыг бичнэ.

Үйлчилгээний газрын нэр гэсэн мөрөнд тухайн тур оператор, тур агент, жуулчны бааз, ангийн отогийн оноосон нэр, байрлаж байгаа аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ын нэрийг бичнэ. Аймаг, сумын кодыг статистикийн хэлтэс, газрын ажилтан нөхнө.

Үйлчилгээний газрын төрөл: Тухайн үйлчилгээний газар нь үйлчилгээний төрөл болох тур оператор, тур агент, жуулчны бааз, ангийн отогийн аль үйлчилгээг явуулж байна түүний өмнөх кодыг дугуйлна.

Б. Үйлчилгээ авсан нийт жуулчдын тоо

1-р мөрөнд үйлчилгээ авсан нийт жуулчдын тоог бичнэ. 2, 3, 10-р мөрүүдийн нийлбэртэй тэнцүү байна.

2-р мөрөнд дотоодын жуулчдын тоог бичнэ. **Дотоодын жуулчинд** байнга оршин суудаг газар нутгаасаа өөр нутаг дэвсгэрт амралт, баяр ёслол, албан ажлаар болон жуулчлалын бусад зорилгоор өөрийн улс дотроо аялж байгаа тус улсын байнга оршин суугч иргэдийг хамруулна.

3-р мөрөнд Гадаадад явуулсан жуулчдын тоог нөхнө. **Гадаадад явуулсан жуулчинд** өөрийн улсаас гадагш өөр улс руу жуулчилсан аливаа улсын иргэн, байнга оршин суугчийг оруулна. Жуулчны бааз болон ангийн отогууд нөхөхгүй.

10-р мөрөнд Гадаадаас хүлээн авсан жуулчдын тоог бичнэ. **Гадаадаас хүлээн авсан жуулчинд** тухайн улсад жуулчлахаар ирсэн өөр улсын иргэн, байнга оршин суугчийг хамруулна.

18-р мөрөнд Зохион байгуулан жуулчдыг аялуулсан нийт аяллын тоог нөхнө. Үүнд дотоодын болон гадаадад явуулсан, гадаадаас хүлээн авсан жуулчдад зориулан зохион байгуулсан аялал орно. Жуулчны бааз болон ангийн отогууд нөхөхгүй.

В. Орлого, зардал

1-р мөрөнд нийт орлогыг бичнэ. Үүнд үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогууд орно.

2-р мөрөнд үндсэн үйл ажиллагааны орлогыг бичнэ. Энд зөвхөн жуулчдаас олсон орлого орно.

6-р мөрийг гадаадад аялуулсан аяллаас олсон орлогыг жуулчны бааз болон ангийн отогууд нөхөхгүй.

7-р мөрөнд үндсэн бус үйл ажиллагааны орлогод барилга байшин түрээсэлснээс олсон орлого, тоног төхөөрөмж түрээсэлснээс олсон орлого, туслах аж ахуйн орлого гэх зэргийг оруулна.

8-р мөрөнд нийт зардлыг бичнэ. Үүнд жуулчидтай холбоотой зардал болон үйл ажиллагааны бусад зардлууд орно.

9-р мөрөнд жуулчидтай холбоотой нийт зардлын дүнг бичнэ. Үүнд Монголд аялуулсан аялалд зарцуулсан болон гадаадад аялуулсан аялалд зарцуулсан нийт зардлыг бичнэ. Мөн нийт жуулчидтай холбоотой зардлаас тээврийн зардал, ор, байрны зардал, хоолны зардал, үзвэр үйлчилгээний зардал, орчуулгын зардал, виз авах түүнтэй холбогдох бичиг баримт бүрдүүлэх, билет захиалгын зардал гэх мэт зардлуудыг хамруулж нийлбэр дүнгээр гаргана. 9-р мөр 10, 11-р мөрүүдийн нийлбэртэй, 12-оос 16-хүртэлх мөрүүдийн нийлбэртэй тус тус тэнцэнэ.

10-р мөр болон 11-р мөрийг жуулчны бааз болон ангийн отогууд нөхөхгүй.

12-р мөрөнд жуулчидтай холбоотой тээврийн зардал буюу жуулчдыг хүлээн авах, аялуулах, үдэн гаргахад зарцуулсан тээврийн зардал орно.

14-р мөрөнд орчуулгын зардал, жуулчдын виз авахтай холбогдсон болон аяллын бусад бичиг баримтын бүрдүүлэлт хийх, онгоц, төмөр зам болон тээврийн хэрэгслээр зорчих билетийн захиалга хийх гэх мэт зардлууд орно.

17-р мөрөнд үйл ажиллагааны бусад зардлуудыг бичнэ. Энэ нь 18-р мөрөөс 43-р мөр хүртэлх зардлуудын нийлбэртэй тэнцүү байна.

27-р мөрөнд 12-р мөрөнд орсон тээврийн зардлаас бусад тээврийн зардал орно.

43-р мөрөнд бусад зардлын дүнг бичих бөгөөд энэхүү зардалд бусдад өгсөн гишүүнчлэлийн татвар, хандив, хүү, торгууль, хөнгөлөлтийн зардал гэх мэт дээрх мөрүүдэд хамрагдахгүй зардлыг оруулна.

44-р мөрөнд нийт орлого, зардлын зөрүүг ашиг, алдагдал гэсэн мөрөнд тавих бөгөөд алдагдал нь хасах тэмдэгтэй байна.

Г. Бусад үзүүлэлт

1-р мөрөнд тухайн жилийн эцэст байгаа нийт ажиллагчдын тоог бичих бөгөөд энд удирдах ажилтан, ажилчид зэрэг тухайн байгууллагад ажилладаг бүх хүмүүс орно.

2-р мөрөнд нийт ажиллагчдаас байнгын ажиллагчдын тоог нөхнө. Байнгын ажлын байранд ажил олгогчтой урт удаан хугацааны, ихэнхидээ тодорхойгүй хугацаагаар хөдөлмөрийн гэрээ байгуулсан иргэнийг **байнгын ажилтан** гэнэ.

3-р мөрөнд нийт ажиллагчдаас эмэгтэй ажиллагчдын тоог салгаж харуулна.

4-р мөрөнд жуулчны бааз болон ангийн отогийн жуулчид хоноглоход зориулсан, бүх эд зүйлээр тоноглогдсон, дэлгэцтэй, үйлчилгээнд бэлэн байгаа нийт орыг (тоогоор) бичнэ. Тур оператор болон тур агентууд үүнийг нөхөхгүй.

5-р мөрийг тур оператор болон тур агентууд бөглөнө. Жуулчдад үйлчилгээ үзүүлсэн хоногийн тоог жуулчдыг Монголд ирсэнээс эхлэн үдэж явуулах хүртэлх жуулчин тус бүрт үйлчилсэн хоногийн нийлбэрээр гаргана. Үүнд мөн дотоодын жуулчин тус бүрт үйлчилсэн хоногийн нийлбэр орно.

6-р мөрийг жуулчны бааз болон ангийн отог бөглөнө. Хүлээн авсан жуулчин тус бүрт үйлчилсэн ор хоногийн нийлбэр буюу хүлээн авсан жуулчдын тоо болон хоносон хоногийн тооны үржвэрүүдийн нийлбэрээр гаргана.

7-р мөрөнд байгууллагын ашиглаж байгаа нийт компьютерийн тоог тухайн жилийн эцсийн байдлаар тодорхойлно.

Г. Нийт хөрөнгийн хуримтлал

Үндсэн хөрөнгө нь хөрөнгийн хуримтлалын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон, нэг жилээс дээш хугацаанд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд давтан эсвэл үргэлжлэн ашиглагддаг биет ба биет бус хөрөнгөөс бүрдэнэ. Нийт хөрөнгийн хуримтлалд бэлэглэсэн, үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг оруулж тооцно.

6-р мөрөнд бусад байгууламж гэсэн хэсэгт орон сууцны болон орон сууцны бус барилгаас бусад байгууламжууд, тухайлбал гудамж, суваг шуудуу зэрэг байгууламжууд орно.

14-р мөрөнд ажлын болон ашиг шимийн мал, амьтан гэсэн хэсэгт хувь хүн, байгууллагын хяналт, удирдлагын дор бүтээгдэхүүнийг давтан үйлдвэрлэх зорилгоор өсгөж буй үржлийн, сүүний чиглэлийн мал, ажлын мал, нэг жилээс дээш хугацаанд ашиг шимээ өгдөг мал, амьтныг оруулна. Тухайн жилд бойжуулсан төлөөс бусад мал, амьтныг өсөж үрждэг хөрөнгөд тооцно.

15-р мөрөнд олон наст ургамал гэсэн хэсэгт нэг жилээс дээш хугацаанд ургац авах зорилгоор ургуулж байгаа жимс, жимсгэний мод болон бусад таримал, модыг оруулна.

20-р мөрөнд бусад биет бус хөрөнгө гэсэн хэсэгт үйлдвэрлэлийн хэрэглээ нь хязгаарлагдмал, зөвхөн тухайн нэгжид өмчлөх эрх нь хадгалагддаг, эсвэл өөр нэгжид лиценцээр эзэмшүүлсэн хөрөнгө орно.

21-р мөрөнд Тайлант ба тайлант оноос өмнө үйлдвэрлэгдэж борлуулахад бэлэн болсон, үйлдвэрлэлийн өөр бусад үйл ажиллагаанд хэрэглэхээр төлөвлөж байгаа бүтээгдэхүүнүүд нь материаллаг эргэлтийн хөрөнгө болно.

28-р мөрөнд Үнэт зүйлсийн хуримтлалд үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглагддаггүй, цаг хугацааны явцад хэрэглээний чанар эсвэл бодит үнэ цэнээ алддаггүй, үнэ нь улам нэмэгддэг зүйлс орно.

31-р мөрөнд бусад үнэт зүйлс гэсэн хэсэгт ямар нэгэн ангилалд ороогүй, жишээ нь үнэт чулуу, металлээр хийсэн үнэ цэнэтэй цуглуулга, гоёлын зүйлс орно.